

“ХАЙР ЭНЭРЭЛТЭЙ хүмүүс БҮРХАНД хамгийн ойр”

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай Нийгэмлэгийнхээ гишүүдэд хандаж дүрвэгсдэд тусалсан бүх улс орнуудад гүн талархлаа нулимын унаган илэрхийлсэн юм.

Европ тива болсон олон улсын даяаны чеэр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн хэлэн уг, 2015 оны 9 сарын 7 ба 20-ны өдөр

Дайнд нэрвэгдсэн улс орны дүрвэгсдийн талаар би байнга боддог. Ургэлж. Зөвхөн өнөөдөр, өчигдөр, уржигдар биш, үргэлж боддог. “Тэд хэрхэн амь зууж байгааг төсөөлөөд үз дээ!”.

Учир нь дүрвэгсэд бүхнээ эрсдэлд оруулж, бүгдийг ардаа орхиод явж байгааг төсөөл дөө. Тэд эрэг дээр амь наасаа золин байж ирж байна.

Тиймээс бид нэг сая ам.долларыг өөр өөр дүрвэгсдийн хуаран луу чадахаараа илгээсэн. Хаа боломжтой газарт нь. Дараа нь эдгээр хандиваа хоёр дахин нэмэгдүүлсэн. Энэ нь зөвхөн дүрвэгсдэд зориулж бараг гурван сая болж байна.

Дүрвэгсдийг хүлээн авч буй хэн боловч бүгд сайхан хүмүүс юм. Тэд надад хувийн том тус хүргэж байна гэж хэлж болно. Мэдээж хэрэг, энэ нь бусад хүмүүст бас тус хүргэж байгаа л даа, гэхдээ миний хувьд, би тэрхүү улс орны төлөө залбирч байна. Тэд маш их, асар их ач буян хураах болно. Тэр улс орнууд цаашдын олон үеийн туршид баян чинээлэг, амар амгалан, төгсөөшгүй аж жаргалаар дүүрэн байх болно. Улс орон даяараа үүнийхээ үр шимийг хүртэх болно.

Эдгээр улс орнууд нь Швед, Австри, Бельги, Грек, Голланд, Испани, Дани, Польш, Финлянд, Норвеги, Румын, Португали, Хорват, Словени зэрэг орнууд бөгөөд бид мөн Турк, Ливан, Иордан, мэдээж Герман, Их Британи зэрэг улсууд руу [хандив] илгээсэн. (Болгар, Кипр, Египет, Эстон, Франц, Унгар, Ирак, Итали, Латви, Люксенбург, Малт, Серби, Сири, Канад, АНУ, НҮБ-ийн Дүрвэгсдийн асуудал хариуцсан агентлагт).

Эдгээр бүх улс орнууд бол жинхэнэ Христийн эсвэл Буддын эсвэл Лалын шашинтай улс орнууд юм.

Тэд үнэхээр Их Багш нарынхаа болон Зөнчийн ном сургаалыг даган баримталж байна.

Бид та бүхэнд алга ташин талархаж байна. Бид та бүхэнд баярлалаа.

Та бүхэнд баярлалаа. Та бүхэнд хөршөө үнэн зүрхнээсээ хайлж, ядарсан

хүмүүст хэрэгтэй үед нь тусалж байгаад бид үнэхээр их талархаж байна.

Энэ бол жинхэнэ ахан дүүсийн ёс. Энэ бол жинхэнэ шашинлаг байдал.

Би үнэхээр их талархаж байна, адислал тань үүрд хэд дахин илүү байх болтугай.

Улс орон тань хөгжин цэцэглэж, амар амгалан, аж жаргалтай байх болтугай.


Ард иргэд тань шаардлагатай бүх л ая тухаар хангагдах болтугай. Таны бусдад

өгч буй ая тух бүхэн танд болон ард иргэдэд тань олон үеэр хэд дахин

нэмэгдэн ирэх болно. Mash их баярлалаа. Бурхан таныг, энэ бүх улс орныг

адислах болтугай, мөн би та бүхэнд биечлэн талархаж байна.

Баярлалаа, үнэхээр их баярлалаа.



Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дээрх QR кодыг уншуулж холбогдох видео болон хаягуудтай танилцаарай.

“Заримдаа бид нөхцөл байдал
өөрчлөгдөж, сайжрах хүртэл залбирах
ёстай. Та нар миний хэлсэн зүйлсийг нутаг
нэгт, өөрийн хамаатан саднууд, найз
нөхдөдөө хэлж тайтгаруулаарай. Нар
маргааш мандан гэрэлтэх болно. Эцэс
төгсгөлгүй шөнө гэж байдаггүй, үүрд
эрэлтэх өдөр гэж байдаггүй. Эерэг
болон сөрөг энергийн талбар байнга
хувьсан өөрчлөгдөж байдаг. Бид
амьдрахын тулд итгэл найдвартай
байх ёстай.”

~ Төгс Гэгээрсэн Их Багш
Чин Хай

Нэг л өдөр та, нэг л өдөр та мэдэх болно
Хэн ч, хэн ч таныг айлгаж чадахгүй!
Хэн ч, хэн ч таныг (дахиж) гэмтээж, зовоохгүй!
Тэр өдөр црэхэд та бүгдийг мэдэх болно
Таны зүрх сэтгэл дэх амар амгалан үүрдшийнх байх болно!
Та үнэхээр хэн болохоо эргэн санах болно
Тэр үед та үүрд мөнхөд эрх чөлөөтэй байх болно!
Зүгээр л миний мэдэх арга замаар таныг мэдээсэй гэж хүсэж байна
Тэр өдөр црэхэд та мэдэх болно
Бурханы хайрлын хамт!
~Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай